



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.03.15 № 1/272  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г ОТОЧ НОМГОН БГБХ НӨХӨРЛӨЛ Г  
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Т.ОДОНТУЯА  
ТАНАА

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлт, төлбөрийн акт, албан шаардлагыг хүргүүлж байна.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт ..... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

5030613

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн  
2023 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altan3233@gmail.com Баян ташаагийн эх аудит ХХК-ийн Аудитор: Б.Хандсүрэн Утас:99087198 Цахим хаяг: bte.audit@yahoo.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....
3. Санхүүгийн тайлангийн  
тодруулга.....
  - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл  
.....
- 4.2 Материаллаг байдал  
.....
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал  
.....
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт  
.....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
.....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах  
асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2024.03.15 № 2/91  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОТОЧ НОМГОН БГБХ  
НӨХӨРЛӨЛ ӨРХИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Т.ОДОНТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв нь тайланд Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансыг аймгийн Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 17/65 тоот тогтоолоор 9,466.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Улсын бүртгэлийн гэрчилгээнд 2022 оны 8 дугаар сарын 05 -ны өдөр нөхөрлөлийн дарга өөрчлөгдсөн өөрчлөлтийг бүртгүүлээгүй байна.

5020341

### **Бусад асуудлын хэсэг**

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв нь тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөг 5 зорилтын 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласныг дээд газар 84.5 хувь “ Хангалттай гэж дүгнэсэн байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Оточ номгон БГБХ нөхөрлөл эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12 сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	215,075.74	560,747.82
1.1.4	ЭМДЕГ-ын авлага		38,327,846.50
1.1.6	Бараа материал	33,118,296.25	25,721,573.00
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>33,333,371.99</b>	<b>64,610,167.32</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	165,336,999.79	199,003,864.67
1.2.2	Биет бус хөрөнгө	10,287,000.00	10,204,500.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>175,623,999.79</b>	<b>209,208,364.67</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>208,957,371.78</b>	<b>273,818,531.99</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
2.1.1.1	Дансны өглөг	32,034.00	32,034.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>32,034.00</b>	<b>32,034.00</b>
2.1.2.10	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>32,034.00</b>	<b>32,034.00</b>
2.3	<b>2. Эзэмшигчийн өмч</b>	<b>141,719,670.73</b>	<b>151,186,507.16</b>
2.3.1	Өмч: -төрийн	141,719,670.73	151,186,507.16
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,056,385.19	20,056,385.19
2.3.8	Эздийн өмч бусад хэсэг	10,122,000.00	10,122,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг:	37,027,281.86	92,421,605.64
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>208,925,337.78</b>	<b>273,786,497.99</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>208,957,371.78</b>	<b>273,818,531.99</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	496,313,557.85	566,059,103.67
2	Ерөнхий ба удирдлагын зардал	518,922,324.96	510,664,779.89
3	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-22,608,767.11	55,394,323.78
4	Татварын дараах ашиг (алдагдал)	-22,608,767.11	55,394,323.78
5	Орлогын нийт дүн	-22,608,767.11	55,394,323.78

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
----------	-----	-----------------	--------------------------	--------------------	----------

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА

Оточ номгон БГБХ нөхөрлөл эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

		үнэлгээний нэмэгдэл			
<b>2021 оны 12 сарын 31 үлдэгдэл</b>	<b>121,118,684.44</b>	<b>20,056,385.19</b>	<b>10,122,000.00</b>	<b>59,636,048.97</b>	<b>210,933,118.60</b>
Тайлант үеийн цэвэр ашиг				-22,608,767.11	-22,608,767.11
Өмчид гарсан өөрчлөлт	20,600,986.29				20,600,986.29
<b>2022 оны 12 сарын 31 үлд</b>	<b>141,719,670.73</b>	<b>20,056,385.19</b>	<b>10,122,000.00</b>	<b>37,027,281.86</b>	<b>208,925,337.78</b>
Тайлант үеийн цэвэр ашиг				55,394,323.78	55,394,323.78
Өмчид гарсан өөрчлөлт	9,466,836.43				9,466,836.4
<b>2023 оны 12 сарын 31 үлд</b>	<b>151,186,507.16</b>	<b>20,056,385.19</b>	<b>10,122,000.00</b>	<b>92,421,605.64</b>	<b>273,786,497.99</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1.	Мөнгөн орлогын дүн (+)	<b>477,543,560.00</b>	<b>561,254,780.67</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	133,382,960.00	154,389,700.00
1.1.3	Татаас, санхүүжилтийн орлого	343,610,600.00	393,581,122.32
1.1.4	Бусад мөнгөн орлого	550,000.00	13,283,958.35
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>444,204,794.93</b>	<b>511,091,608.59</b>
1.2.1	Ажилчдад төлсөн	208,621,610.00	207,851,703.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	60,472,723.00	62,243,013.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	83,261,135.00	92,560,624.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн /холбоо, бичиг хэргийн зардал/	18,653,286.00	24,684,196.58
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,534,000.00	6,574,500.00
1.2.7	Даатгалын байгууллагад төлсөн	248,500.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	66,413,540.93	117,177,572.01
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-2,366,534.93</b>	<b>345,672.08</b>
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>35,705,300.00</b>	<b>49,817,500.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	35,705,300.00	49,817,500.00
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-2,366,534.93</b>	<b>345,672.08</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,581,610.67</b>	<b>215,075.74</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>215,075.74</b>	<b>560,747.82</b>

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА



**БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА:****А. Оточ номгон БГБХ-нөхөрлөлийн танилцуулга**

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн зорилго нь Иргэн бүрт чанартай тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэхэд оршино. Тус нөхөрлөл нь дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж иргэдийнхээ эрэлт хэрэгцээнд тохирсон тусламж үзүүлэх
- Харьяа хүн амын эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэх
- Хүний нөөцийг бэхжүүлэх
- Ээлтэй орчинг бүрдүүлэх

**Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв дараах үдсэн тусламж үйлчилнэ. Үүнд:**

- Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх
- Оношилгоо, эмчилгээ
- Яаралтай тусламжийн үйлчилгээ
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ
- Сэргээн засах тусламж үйлчилгээ
- Хяналт
- Сувилахуйн тусламж үйлчилгээ
- Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ
- Өдрийн эмчилгээ
- Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ

**Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ**

- Статистик, дүн бүртгэл мэдээлэл, судалгаа
- Мэдээлэл, сургалт сурталчилгаа
- Дархлаажуулалтын тусламж үйлчилгээ
- Халдварт бус өвчний эрт илрүүлгийн тусламж үйлчилгээ
- Халдварт өвчний үеийн тусламж үйлчилгээ
- Эмийн зохистой хэрэглээ гэх мэт чиглэлүүдээр эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг ард иргэдэд үзүүлэн ажиллаж байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв нь Засгийн газрын 1999 оны 149 тоот тогтоолыг үндэслэн 2001 онд бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА

нөхөрлөлийн хэлбэрээр байгуулагдаж одоог хүртэл Дуурсах 3-р баг, Эрдэнэмандал 2-р багийн нийт 1980 өрхийн 7340 хүн ам, түр оршин суугчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны 08 тоот тогтоол "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай";
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай"
- ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоол "Журам шинэчлэн батлах тухай"

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар судалж, танилцсан болно.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА

Оточ номгон БГБХ нөхөрлөл эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Оточ номгон БГБХ-нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,861.2 мянган төгрөгөөр буюу 31.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	215.1	560.7	345.6
Авлага	0	38,327.8	38,327.8
Бараа материал	33,118.2	25,721.6	-7,396.6
Үндсэн хөрөнгө	175,624.0	209,208.4	33,584.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>208,957.3</b>	<b>273,818.5</b>	<b>64,861.2</b>
Өр төлбөр	32.0	32.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	208,925.3	273,786.5	64,861.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>208,957.3</b>	<b>273,818.5</b>	<b>64,861.2</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 345.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 38,327.6 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын газраас 4 багц үйлчилгээний 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс хойших авлагын үлдэгдэл нөлөөлсөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 7,396.6 мянган төгрөгөөр буурсан нь хангамжийн материал 13,199.0 мянган төгрөг, эм боох материал дансны үлдэгдэл 12,522.6 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА

Үндсэн хөрөнгө дансны 209,208.4 мянган төгрөг болж үлдэгдэл 33,584.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь машин тоног төхөөрөмж данс 13,266.8 мянган, бусад үндсэн хөрөнгө данс 46,017.5 мянган, төгрөгөөр нэмэгдсэн, тайлант оны элэгдлийн зардал 25,617.5 мянган төгрөг байгаа зэрэг нөлөөлжээ.

Өмнөх оны өглөг 32.0 мянган төгрөгийг барагдуулаагүй байна. Татварын өглөгийг тухайн онд төлөөгүтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 273,786.5 сая төгрөг болж 64,861.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант он 55,394.3 мянган төгрөгийн ашигтай, үндсэн хөрөнгөнд Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 17/65 тоот тогтоолоор үнэ төлбөргүй шилжиж ирсэн 9,466.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв нь тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөг 5 зорилтын 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласныг дээд газар 84.5 хувь “ Хангалттай гэж дүгнэсэн байна.

### **3.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Тайлант онд зорилтот төлөвлөгөө батлуулаагүй байна. Тайлант оны гүйцэтгэлээр 566,059.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 510,664.8 мянган төгрөгийн зардал илэрхийлж 55,394.3 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна. Харин өмнөх оноос орлого 83,711.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, нийт зардал 8, 257.5 мянган төгрөгөөр буурсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу .Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх өрхийн эрүүл мэндийн төв түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА

байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2024 оны 02 дүгээр сарын 01-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Хоролсүрэн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Оточ номгон БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв нь энэ хуулийн хүрээнд өмнөх оноос бараа үйлчилгээний бусад зардал 6,689.0 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,736.7 мянган, цалингийн зардал 4,446.8 мянган төгрөгөөр тус тус өсч, харин бичиг хэргийн зардал 779.8 мянган, хангамж, бараа материалын зардал 665.3 мянган, нийт зардал 8,257.5 мянган төгрөгөөр буурсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Шилэн дансны цахим системд мэдээлэх ёстой орлогын 547,970.8 мянган төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай байна.

Үүнд:

1. Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 15–ны өдрийн А/212 тушаалын хавсралт “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 1.3 “Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн төвийн баг нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна” гэсэн заалтын дагуу байгуулагдсан хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ” гэсэн хуулийн заалттай нийцэхгүй байна.

2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 42 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх” гэрээний загварт орон нутгийн өмчийг эзэмшүүлэх, ашиглах, түрээслэх заалт нь тодорхой бус, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн даргатай байгуулсан “Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ”-ний 4.1.4 Төвийн ашиглаж буй орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналт,... 8.1 Төв нь Аймгийн өмчийн газартай “Өмч эзэмших гэрээ”байгуулна, 8.2 Төвд ашиглагдаж буй өмч хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хийнэ гэсэн заалтууд нь хоорондоо зөрчилтэй байна.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 306.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 306.7 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Залруулагдаагүй нийт 306.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА



### 5.1 5.1 Төлбөрийн акт

Нэг ажилтанд үр дүнгийн урамшууллыг тушаал шийдвэрт зааснаас 306.7 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хий 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 306.7 мянган төгрөгийг дарга, нягтлан бодогчоор төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Улсын бүртгэлийн гэрчилгээнд 2022 оны 8 сард нөхөрлөлийн дарга өөрчлөгдсөн өөрчлөлтийг бүртгүүлээгүй байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ: гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна .

#### Шийдвэрлэсэн нь:

Хуулийн этгээдийн өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт хийлгэж байх.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 20 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэр бүхий 1 ажилтанд үр дүнгийн урамшуулал 306.7 мянган төгрөгийг илүү олгосон байна	1	306.7	1	306.7					
Дүн	1	306.7	1	306.7					

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>						
Улсын бүртгэлийн гэрчилгээнд 2022 оны 8 сард нөхөрлөлийн дарга өөрчлөгдсөн өөрчлөлтийг бүртгүүлээгүй байна.	1		1			
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>			

Аудитын код: БНА-2024/06/НА-СТА-ОНА